

СМАРТ ДАТА ХХК

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА



2026

Developed by
Smart DATA
SMART SOLUTIONS.
DELIVERED

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Смарт Дата ХХК нь 2014 онд анх үүсгэн байгуулагдсан бөгөөд тухайн цагаас эхлэн бизнесийн болон төрийн байгууллагуудад зориулсан мэдээллийн технологийн шийдлүүдийг харилцагчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж ирсэн. Манай компани нь дараах үндсэн чиглэлүүдийг барин ажиллаж байна. Үүнд:

- Программ хангамж хөгжүүлэлт (**Software Development**)
- Мэдээлэл технологийн зөвлөх үйлчилгээ (**IT Consulting**)
- Дэд бүтэц байгуулах тохируулах (**Infrastructure**)
- Өгөгдлийн агуулах, анализ хийх (**Data Warehouse, BI**)

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Мэдээллийн технологийн ухаалаг шийдлийг хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж, түүнийгээ амжилттай нэвтрүүлэхийн тулд бид дараах үндсэн зарчмуудыг барин ажиллаж байна. Тэдгээрээс дурдвал:

- Байгууллагын дотоод үйл ажиллагааг дэмжих
- Давтагдсан үйл ажиллагааг багасгаж, зардлыг бууруулах
- Өгөгдлийн үнэн зөв байдлыг хангах
- Олон түвшний нууцлал, хамгаалалтын боломжуудыг хэрэглэх
- Системийн ажиллагааны найдвартай байдлыг хангах дэд бүтэц байгуулах
- Байгууллагын үйл ажиллагааны төрөл бүрийн өгөгдөл дээр дүн шинжилгээ хийж, шийдвэр гаргах түвшний мэдээллийг хурдан хугацаанд удирдлагуудад гаргаж өгөх
- Мэдээллийн технологийн сүүлийн үеийн чиг хандлага дээр тулгуурлан өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх


Эдгээр зарчим зорилгын хүрээнд боловсруулж буй бүтээгдэхүүн, оролцож буй төслүүдээ цаг хугацаанд нь хэрэгцээ шаардлагын дагуу, чанарын өндөр түвшинд боловсруулан, шинэ шинэлэг зүйлүүдийг өөрсдийн санаачилгаар нэмж хөгжүүлэн нэвтрүүлсээр ирсэн.

Алсын хараа

Манай компанид ажиллаж буй хүн бүр сэтгэл хангалуун, нэгэн зорилгын дор нэгдэн ажиллаж өөрсдийн мэдлэг чадвар, оюун ухаан шингэсэн шийдлүүдийг боловсруулан Монгол улсын нийгэм, эдийн засагт өөрсдийн хувь нэмрийг оруулж дэлхийд өрсөлдөхүйц компанийг бий болгоно.

Эрхэм зорилго

Бид мэдээллийн технологийн шийдлийг өөрсдийн **БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭГЭЭРЭЭ** дамжуулан хүн бүрд хүртээмжтэй, таны амьдралд үнэ цэнэ, баяр баясал бэлэглэх чин хүслийг баримтална.



Биднийг сонгох шалтгаан

Чанартай мэдээллийн технологийн шийдлүүдийг харилцагч байгууллагад нийлүүлэх, хэрэгжүүлж буй систем бүртээ өөрсдийн ур ухааныг шингээн урлан, хөгжүүлж, нэвтрүүлж байна.

- Танай байгууллагын үйл ажиллагааг маш нарийвчлан судалж, мэдээллийн технологийн шийдлээр улам боловсронгуй болгоход төвлөрнө.
- Дан ганц технологийн шийдэл гэхээс илүүтэй процессын шийдлүүдийг байгууллагад нэвтрүүлэн ажиллаж байна .

Олон жилийн
туршлага

Чадварлаг
хамт олон

Ухаалаг
шийдлүүд

Асуудлыг хурдан
шийдвэрлэгч

SOFTWARE DEVELOPMENT



Бид хэрхэн ажилладаг вэ?



Судалгаа

Хэрэглэгчийн шаардлагыг нарийвчлан тодорхойлж, одоогийн нөхцөл байдлын судалгаа хийнэ.




Дизайн

Шаардлага дээр үндэслэн технологийн болон бизнес процесс гарган дизайныг боловсруулна.



Хөгжүүлэлт

Шаардлага, дизайн, загвар үндэслэн программ хангамжийн кодчилал, дэд бүтцийг бий болгоно.



Анализ ба дэмжлэг

Амжилттай нэвтрүүлсний дараа байнгын сайжруулалт, дэмжлэг үйлчилгээг үзүүлдэг.

Он цагийн хэлхээ

2014

ҮҮСГЭН
БАЙГУУЛАГДАВ

2015

ОНЛАЙН ХУДАЛДААНЫ
ПЛАТФОРМ (E-COMMERCE)
www.megashop.mn,

2015

ДОТООД МЭДЭЭЛЛИЙН
СИСТЕМ (E-OFFICE)
Скайтел ХХК-д хүлээлгэн өгч
нэвтрүүлсэн.

2018

ГАЗРЫН УДИРДЛАГЫН НЭГДСЭН СИСТЕМ
ГЗБГЗЗГ-ын захиалгын дагуу Кадастр, Газар
зохион байгуулалт, Мониторинг, Татвар төлбөр,
Үнэлгээ, Олон нийтийн гэсэн дэд системүүдээс
бүрдсэн Газрын удирдлагын системийг хийж
эхлүүлсэн.

2017

БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖЕМЕНТИЙН
СИСТЕМ
Аймаг дундын отрын бэлчээр
ашиглалтын захиргаанд зориулсан
бэлчээрийн менежментийн төслийг
хэрэгжүүлэв.

2019

ОРОН НУТГИЙН СУРГАЛТ
Газрын удирдлагын цахим системийг
амжилттай хэрэгжүүлж орон нутгаар
бүсчилсэн сургалтыг 21 аймаг, нийслэл
дүүргүүдэд амжилттай зохион байгуулсан.

2020

ГАЗРЫН НЭЭЛИТТЭЙ
ПОРТАЛ (EGAZAR.GOV.MN)
БОЛОН ГАР УТАСНЫ
([EGAZAR APP](#))

2022

ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЦАХИМ СИСТЕМ
(EBARILGA.UB.GOV.MN)

2024

ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖЫН
УДИРДЛАГЫН МЭДЭЭЛЛИЙН
СИСТЕМ (UBROAD.MN)

2024

ГАЗРЫН БИРЖИЙН ЦАХИМ
СИСТЕМ (MLE.MN)

2023

ХОТ БАЙГУУЛАЛТЫН
КАДАСТРЫН ЦАХИМ
СИСТЕМ (URBAN.GOV.MN)

2025

ЦАХИЛГААН БАЙГУУЛАМЖЫН
ОРОН ЗАЙН GRID СИСТЕМ
(GRID.TRANSCO.MN)

УДИРДЛАГЫН ТАНИЛЦУУЛГА



Эрдэнэбилэгийн ЭРДЭНЭБАЯР
(Founder & CEO)

2007 оноос эхлэн Программ хангамжийн салбарт ажиллаж эхэлснээсээ хойш хийж хэрэгжүүлж буй төсөл, бүтээгдэхүүнүүддээ өөрсдийн сэтгэл, мэдлэг чадвараа шингээн амжилттай нэвтрүүлж ирсэн билээ. Гар бие оролцсон олон төслүүд маань засаг болон бизнесийн байгууллагууд дээр одоог хүртэл амжилттайгаар ажилласаар байна.

Бид харилцагч байгууллагуудтайгаа урт хугацаанд хамтран ажиллаж мэдээллийн технологийн шинэлэг шийдэл, сайжруулалтыг байнга нэвтрүүлэхийг зорьдог ба хамтын хөгжлийг илүүд эрхэмлэн ажиллаж байна.

2014 оноос өмнөх оролцож байсан томоохон ажлууд

2009

Монгол Улсын төсвийн төлөвлөлтийн систем

Сангийн яам

2010

Хурууны хээ иргэний шинэчлэсэн бүртгэл

Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар

2011

Анхан шатны шүүхийн систем

Иргэний хэргийн анхан шатны шүүх

2012

Иргэний бүртгэлийн систем
(Цахим иргэний үнэмлэх)

Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар

2013

Өгөгдлийн агуулах, ухаалаг тайлангийн систем
(Data Warehouse, Business Intelligence)

Татварын Ерөнхий Газар

2014

Цахим тайлангийн систем
(e-tax.mta.mn)

Татварын Ерөнхий Газар

Бидний үйлчилгээ

Програм хангамж боловсруулах

Харилцагч байгууллагуудын хэрэгцээ шаардлагыг судлан ойлгож, анализ хийн архитектур дизайныг боловсруулдаг. Загвар шийдлийнхээ дагуу сүүлийн үеийн техник, технологийг ашиглан цаашид хөгжих боломж бүхий Ухаалаг программ хангамжийг боловсруулан нэвтрүүлдэг.

Мэдээллийн технологийн зөвлөх үйлчилгээ

Байгууллага нь үйл ажиллагаандаа мэдээллийн технологийн дэвшилтийг хэрхэн нэвтрүүлэх талаар шийдэл хэрэгтэй үед Одоо байгаа мэдээллийн технологийн шийдлүүд, дэд бүтцэд дүн шинжилгээ хийлгэж сайжруулах шаардлагатай үед

Дэд бүтэц байгуулах, тохируулах

Мэдээллийн технологийн шийдлийг нэвтрүүлэхтэй холбоотой сервер, тоног төхөөрөмж тэдгээрийн хоорондын уялдаа холбоог хамгийн тохиромжтой байдлаар холбох, тохируулах Байгууллага дээрх бүх төрлийн өгөгдөл, мэдээллийг уялдан зохицуулах

Өгөгдлийн агуулах, анализ хийх

Байгууллага дээр цугларч байдаг олон төрлийн эх үүсвэрийн (Database, Excel, File) өгөгдлүүдийг нэг мэдээллийн санд төвлөрүүлж цэгцлэн дүн шинжилгээ, анализ хийх боломжийг бүрдүүлдэг. Хаанаас ч, хэдийд ч өдөр тутмын мэдээллээ хянах нь өнөөгийн хамгийн чухал үзүүлэлт юм.

Програм хангамж хөгжүүлэлт

Software Development


Хөгжүүлэлт ба кодчлол

Сүүлийн үеийн технологиуд дээр суурилсан Ухаалаг шийдэл бүхий системүүдийг боловсруулж байна. Бид программ хангамж боловсруулахдаа төсөл боловсруулах аргачлал болон программ хангамж хөгжүүлэх алхмуудын дагуу боловсруулан хүлээлгэн өгдөг.

Төслийг боловсруулахдаа алхмууд буюу төсөл эхлүүлэх, төслийг төлөвлөх, төсөл боловсруулах, хянах болон шалгах, нэвтрүүлэх болон хаах гэсэн үе шаттайгаар хэрэгжүүлж байна.


Төсөл боловсруулах аргачлал

- Газар зүйн мэдээллийн систем
- Веб систем
- Десктоп систем
- Geographical Information System
- Web System
- Desktop System



Програм хангамж боловсруулах үе шат

Төсөл боловсруулах үе шат буюу хөгжүүлэлтийн шатанд ирснээр программ хангамжийг доорх зурагт харуулсны дагуу үе шатуудтайгаар хэрэгжүүлдэг. Ингэснээр хөгжүүлэлтийг эмх цэгцтэй, алдаагүй, амжилттай дуусгах үндэс болдог.



- Laravel Framework
- React JS / React Native
- HTML / CSS / Javascript
- .NET Framework / C#
- PostgreSQL / PostGIS
- GeoServer
- Ubuntu OS
- Socket

Мэдээллийн технологийн зөвлөх үйлчилгээ

Зөвлөх ба нэвтрүүлэх

Бизнесийн болон төрийн байгууллагын дотоод болон гадаад үйл ажиллагааг мэдээллийн технологийн шийдэлтэй хэрхэн уялдуулан холбож, тухайн байгууллагын зорилго чиглэлд нийцүүлсэн, ажилтнуудын уялдаа холбоог сайжруулан, цаг хугацаа, хөрөнгө төсөв хэмнэж болох техник, технологийн зөвлөгөөг гаргаж өгдөг.

Зөвлөх үйлчилгээ



Байгууллага нь мэдээллийн технологийн шийдлүүдийг өөрсдийн үйл ажиллагаандаа ашигладаг бөгөөд дараах тохиолдлуудад зөвлөх үйлчилгээг өгөх боломжтой:

- Программ хангамж – Ямар төрлийн программ хангамж ашиглах, одоо ашиглаж буйг сайжруулах
- Мэдээллийн сан – Олон төрлийн мэдээллийг хэрхэн цэгцтэй удирдах, ачаалал болон хурдыг тохируулах
- Бизнес процесс – Дотоод бизнес процессыг мэдээллийг технологитой хэрхэн уялдуулах
- Системүүдийн холболт – Төрөл бүрийн системүүдийг хооронд холбож, мэдээлэл солилцох шаардлагатай үед
- Нууцлал, хамгаалалт – Мэдээллийн аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар
- Сервер – Тоног төхөөрөмж, серверүүдийг зөв зохистойгоор удирдан зохион байгуулах үед
- Сүлжээ – Байгууллагын дотоод болон гадаад сүлжээг тохируулах үед
- Хост – Хэрэгцээ шаардлагадаа зориулан хостын зохион байгуулалт, серверүүдийн хандалтыг үүсгэх үед гэх мэт.

Дэд бүтэц байгуулах, тохируулах үйлчилгээ

Тохируулах ба хянах

Бидний хувьд өнгөрсөн хугацаанд хийж хэрэгжүүлсэн ихэнх төслүүдийн хувьд дэд бүтэц, тоног төхөөрөмжүүдийг өөрсдөө тохируулан, хооронд нь холбож ажиллуулах ажлуудыг хийдэг байсан. Үүнтэй холбоотойгоор технологийн дэд бүтэц байгуулан, тохируулах нь бидний гол чиглэлүүдийн нэг болсон. Дэд бүтцийг байгуулж, түүн дээр хөгжүүлсэн программ хангамжийг суурилуулан ажиллуулах, олон хэрэглэгч зэрэг хандах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах нь хамгийн чухал ажил юм.

Вэбийн ачаалал тэнцвэржүүлэх

Олон хэрэглэгч зэрэг хандах шаардлагатай ба серверүүдийн ачааллыг тэнцвэртэйгээр зохицуулахын тулд Ачаалал тэнцвэржүүлэх (Load Balancing) аргачлалыг хэрэгжүүлдэг.

Сервер болон ачаалал тэнцвэржүүлэгчийн хувьд Apache, HAProxy зэрэг технологиудыг ашиглан тохируулдаг. Мөн физик ачаалал тэнцвэржүүлэгч төхөөрөмжүүдийг ашиглан тохируулах боломжтой.



Мэдээллийн сангийн найдвартай байдлыг хангах

Аливаа мэдээллийн системүүдийн амин сүнс болсон мэдээллийн сангийн хувьд түүн дотор агуулагдаж буй өгөгдлийн үнэн зөв байдал, серверүүдийн найдвартай ажиллагаа хамгийн чухал байдаг.



Тэрхүү шаардлагыг хангахын тулд байнгын ажиллагаатай байх дэд бүтцийг доорх байдлаар үүсгэдэг. Мөн нөөц сервер тохируулах г.м шийдлүүдийг санал болгодог байгаа.

Мэдээллийн сангийн серверүүдийг зөвхөн бичих болон унших чиглэлээр тохируулснаар сервер ирэх ачааллыг эрс бууруулж программ хангамж хэвийн ажиллах нөхцөлийн бүрдүүлдэг.


Өгөгдлийн агуулах, анализ хийх


Ангилах ба тооцоолох

Байгууллага нь өөрийн үнэ цэнтэй өгөгдөл (data) дээрээ үндэслэн тайлан мэдээ гаргах, шинжилгээ хийх зайлшгүй шаардлагатай болсон билээ. Бидний хувьд тэрхүү өгөгдлийг хэрхэн зөв зохистойгоор хадгалах, хамгаалах технологийн шийдлийг нэвтрүүлэх, суулгах болон түүн дээрээс тайлан шинжилгээ, судалгааг үнэ бодитоор гаргах боломжийг бүрдүүлж өгдөг билээ.

Өгөгдлийн агуулах бүрдүүлэх (data warehouse)

Таны байгууллага дээр байрлах цаасан болон цахим мэдээллийг өгөгдлийн агуулахад хэрхэн байршуулах тал дээр доорх зурагт харууллаа. Өгөгдлийг цахим байдалд хөрвүүлэн, нэг стандарт загвараар хадгалснаар тайлан судалгаа гаргаж авахад маш хялбар болдог. Мөн өгөгдлийн агуулахад байршуулахдаа тодорхой аргачлал, системүүдийг ашигладаг байгаа.





Тайлан аналитак

Байгууллагын өгөгдлүүдийг нэгэнт стандарт загварын дагуу өгөгдлийн агуулахад байршуулснаар тайлан шинжилгээ, судалгааны системүүдийг холбох шаардлагатай болно. Энэхүү систем дээр удирдах албан тушаалтан хүмүүсийг ажиллаж сургах, тайлан зохиох зэрэгт сургадаг байгаа.



Амжилттай хэрэгжүүлсэн шийдлүүд

1

Газрын удирдлагын нэгдсэн систем (Land ERP)

Төслийн тухай товч


Монгол Улсын нутаг дэвсгэр дээрх газар олголт, төлөвлөлт, түүний төлбөр, татвар болон газрын хяналт, мониторингийн чиглэлийн системүүдийг 2018 - 2022 оны хооронд шинэчилсэн технологийн дагуу хийж хэрэгжүүлсэн. Бидний гар бие оролцож хэрэгжүүлсэн системүүд Газар зохион байгуулалтын систем, Газрын кадастрын систем, Газрын төлбөр, татварын систем, Газрын мониторингийн систем болон нээлттэй вэб портал болон гар утасны аппликэйшны болох egazar зэргийг хийж хэрэгжүүлсэн.

Шийдвэрлэх асуудал

- Газрын кадастрын систем нь Монгол Улсын хэмжээнд 21 аймаг, 330 сум дээр бие даан ажиллаж, даамал тус бүрийн компьютер дээр ажилладаг байв.
- Газар зохион байгуулалт, төлбөр, татварын систем, газрын мониторингийн систем бий болоогүй байв.
- Бусад байгууллагуудтай мэдээлэл солилцож чаддаггүй байв.
- Газрын мэдээллийг олон нийтэд нээлттэйгээр харуулж чаддаггүй байв.
- Иргэд олон нийтээс цахимаар өргөдөл, хүсэлт авч чаддаггүй байв.
- Олон газар байрлаж буй мэдээллийн сангуудыг нэгтгэх зэрэг асуудлуудыг шийдэхээр эхэлсэн.

Нэвтрүүлсэн шийдэл

- Программ хангамж боловсруулах алхмуудын дагуу шаардлага болон дизайныг боловсруулж Land ERP системийн архитектурыг гаргасан.
- Захиалагчийн шаардлага болон бидний гаргасан шийдлийн дагуу нээлттэй эхийн (Open Source) технологиуд дээр хөгжүүлэлтийг хийсэн.
- Орон зайн мэдээллийг дотооддоо болон олон нийтэд харуулах үүднээс газрын зургийн сервер (Geoserver) тохируулан оруулж ирсэн.
- Иргэд олон нийтэд газрын мэдээллийг хүргэх, хүсэлт хүлээн авах үүднээс нээлттэй веб портал болон гар утасны аппликейшн байх шаардлагатай болсон
- Улс орон даяар албан хаагчдын хандах нэгдсэн дотоод удирдлагын систем зэрэг шийдлийг хэрэгжүүлсэн



Төслийн мэдээлэл

Захиалагч: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар

Хэрэгжүүлсэн огноо: 2018 - 2022он

Нээлттэй портал: www.egazar.gov.mn


Гар утасны апп: egazar

2

Нийслэлийн хот байгуулалтын систем (Urban City ERP)

Төслийн тухай товч

Нийслэлийн хот байгуулалт, хотын стандартын газар нь Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн боловсруулах ажлыг зохион байгуулж батлуулах, хэрэгжилтийг нийслэлийн эдийн засаг, нийгмийн нөөц боломжид тулгуурлан иргэдийн оролцоотой төлөвлөх, хот байгуулалтын үйл ажиллагааг орчин үеийн дэвшилтэт технологийг ашиглан иргэн, хуулийн этгээдэд хурдан шуурхай, хүртээмжтэй байдлаар зохион байгуулах, хяналт тавих үйл ажиллагааг явуулдаг Нийслэлийн харьяа байгууллага юм. Тус байгууллагын хувьд өмнө нь десктоп программ хангамжийг ашиглан хот байгуулалтын мэдээллийн санг удирдан зохион байгуулдаг байсан бөгөөд иргэд олон нийтээс цаасаар хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсний дараа мэдээллийн санд орон зайн мэдээллийг бүртгэдэг байсан.



Шийдвэрлэх асуудал

Иргэд, ААН, олон нийтийн зүгээс тулгардаг асуудал, бэрхшээлүүд

- Зөвшөөрөлтэй, зөвшөөрөлгүй баригдсан барилга байгууламжийн тухай мэдээллийг харахад хүндрэлтэй
- Зөвшөөрөлгүй баригдаж буй барилга байгууламж, хот байгуулалтыг үйл ажиллагаатай холбоотой зөрчлийг байршил, баримтжуулсан зургаар мэдээлэх боломжгүй
- Барилга байгууламж барих хүсэлт гаргах болон бусад төрлийн үйлчилгээнүүдийг авахад цаг хугацаа их зарцуулах, цаасан хэлбэрээр хүсэлтээ өгдөг
- Хөгжлийн болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, бусад олон нийтэд нээлттэй давхаргын мэдээллүүдийг хүссэн үедээ харах боломжгүй

Хот байгуулалт хөгжлийн газрын мэргэжилтнүүдэд тулгардаг асуудал, бэрхшээлүүд

- Системд аль хэдийн хадгалагдсан байгаа мэдээлэл автоматаар татагдаж гарч ирдэггүйн улмаас дахин гараас оруулах нь мэдээллийн зөрүү үүсэх, цаг хугацаа алдах бэрхшээлтэй.
- Бусад системээр дамжин ирсэн иргэд олон нийтийн хүсэлтүүдийг тухайлсан систем тус бүр рүү нэвтрэн орж олон эх үүсвэр дээр ажиллах нь зарим хүсэлтүүд шийдвэрлэгдэхгүй удах, цаг алдах зэрэг асуудлууд үүсдэг.
- Системээс хэвлэгдэн гарсан бичиг баримтууд одоо ашиглаж буй форматын дагуу үүсдэггүйгээс гараар дахин засварлан хугацаа алдах мөн шивэлтийн зөрүү үүсэх эрсдэлтэй.
- Мэдээллийг өөр өөр программ хангамж дээр дахин, дахин шивж оруулах нь мэдээлэл өөрөөр хадгалагдах, шивэлтийн зөрүүний алдаа үүсэх эрсдэлтэй бөгөөд цаг хугацаа алддаг.

Төслийн үр дүн

- Иргэн ААН-ээс бүх төрлийн хүсэлтүүдийг цахимаар илгээх, шийдвэрлэх боломж бүхий нэгдмэл ажиллагаатай Urban ERP бий болсон. Ингэснээр цаг хугацаа хэмнэж, иргэн ААН онлайнаар хүсэлтээ илгээж хянах боломжтой болсон.
- Иргэн, ААН ДАН-р нэвтрэн ebarilga.ub.gov.mn дээр өөрийн нэгж талбарт үндэслэн ямар хэмжээтэй газарт барилга барих боломжтойг шалгах боломжтой болсон.
- Хүсэлт гаргагч иргэд, ААН байгууллагууд болон барилга барих үйл ажиллагаанд оролцогч этгээдүүдийн нэгдсэн сантай болсон бөгөөд дахин дахин оролцогчдын мэдээллийг бүртгэх шаардлагагүй болсон.
- Иргэд, ААН нээлттэй орон зайн давхаргуудыг онлайнаар харах боломжтой болсон.
- Албан хаагчдад ашиг сонирхлын зөрчил үүсгэхгүйн тулд барилга барих үйл ажиллагаатай холбоотой хүсэлтүүдийг тойргоор болон бусад аргачлалаар хуваарилдаг болсон.
- Мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг шалгах шалгууртай болсон.
- Хүсэлтийн төрөл бүрээр байгууллагын дотоод үйл ажиллагааны процессын дагуу ажлын урсгал буюу бизнес процессыг үүсгэж тохируулах боломжтойгоор хийгдсэн тул ирээдүйн программ хангамж хөгжүүлэлтийн зардлыг бууруулсан.
- Хүсэлт, бүртгэлүүдтэй холбоотой хавсралт файл, батлагдсан файлууд цахим архивын нэгдсэн санд хадгалагддаг болсон.
- Мэдээллийн санд хүссэн тооны давхаргын төрлүүдийг үүсгэх, тэдгээр давхаргууд дээрээ бүртгэх атрибут үзүүлэлтийг хүсэлтийн төрөл бүрээр динамикаар тохируулах боломжтой.

Төслийн мэдээлэл

Захиалагч: Хот байгуулалт, хөгжлийн газар
Хэрэгжүүлсэн огноо: 2021он
Нээлттэй портал: www.ebarilga.ub.gov.mn
Гар утасны апп: EBarilga

3

Улсын хот байгуулалтын кадастрын систем (Urban State ERP)

Төслийн тухай товч


Улсын хэмжээний хот байгуулалтын кадастр нь улсын хэмжээнд газар нутгийн хөгжлийн болон хот, суурин газрын хот байгуулалтын төлөвлөлт, барилгажилтын баримт бичиг болох бөгөөд хот байгуулалтын кадастрт геодези, байр зүй, зурагзүйн материал, гидрогеологийн тухай мэдээлэл, хот байгуулалтын хөгжлийн болон газар, барилгажилтын тухай мэдээлэл, инженерийн, зам тээврийн болон нийгмийн дэд бүтэц ба газар нутгийн тохижилтын тухай мэдээллүүд юм. Эдгээр мэдээллийг бүрдүүлэгч нь аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрууд бөгөөд тус бүс нутагт баригдах барилга байгууламж, өргөтгөл, засвар шинэчлэлийн ажилд барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг зохих журмын дагуу олгож, барилгын ажлын явцад бусад мэдээллүүдийг бүртгэж, барилга баригдаж дууссаны дараа гүйцэтгэлийн зургийг хүлээн авч, БАОК-н дүгнэлтийг олгох, тухайн нутагт байгаа бусад дэд бүтэц, объектууд болон тэдгээрийн дэлгэрэнгүй мэдээллүүдийг бүртгэлжүүлдэг. Захиалагчийн хувьд бүртгэлжүүлэх орон зайн болон орон зайн бус мэдээллийн төрлүүдийг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага тулгарсан бөгөөд мөн өмнөх системийн дутагдлыг арилгах, нэмэлт боломжоор хангах шаардлага үүссэн.

Шийдвэрлэх асуудал

- Хуучин системийн хувьд шинээр бүртгэх орон зайн болон орон зайн бус мэдээллийн төрөл буюу давхарга нэмэгдэх бүрд нэмэлт хөгжүүлэлт хийгдэж хөгжүүлэгч компаниас хамааралтай байсан.
- Үүнийг дагаад мэдээллийн сангийн үндсэн хэсгийн бүтэц зохион байгуулалтын хувьд уян хатан бус буюу динамик бус байсан.
- Иргэд олон нийтийн зүгээс зөвхөн барилга барих зөвшөөрлийн анхны буюу Архитектур төлөвлөлтийн даалгавар авах хүсэлтээ илгээгээд бусад үйл явц дах харилцааг цаасан байдлаар хүсэлт гаргадаг байсан бөгөөд барилга, байгууламж барихтай холбоотой бүх хүсэлтийг онлайнаар илгээх боломжийг бүрдүүлэх шаардлагатай байсан.
- Шаардлагатай холбогдох байгууллагуудтай мэдээлэл солилцож чадахгүй байв.

Нэвтрүүлсэн шийдэл

- Тулгамдаж байсан мэдээллийн сангийн суурь бүтцийг өөрчилсөн бөгөөд хуучин датаг хөрвүүлж шинэ бүтэц рүү оруулсан.
- Шинээр зохион байгуулсан мэдээллийн сангийн бүтэц нь дурын хүссэн шинэ бүртгэл, хүсэлтийн төрөл, орон зайн мэдээллийн төрлөөр динамикаар үүсгэн түүний хүрээнд бүртгэх дэлгэрэнгүй мэдээллээ нэмэлт хөгжүүлэлт хийхгүйгээр захиалагч тал өөрсдөө удирдан зохион байгуулах боломжтойгоор зохион байгуулсан.
- Төслийг гүйцэтгэхдээ хэрэглэгчийн хэрэгцээ шаардлага, одоогийн нөхцөл байдлыг судалж, одоогийн болон ирээдүйд бий болгох процессын зураглалыг нарийвчлан хийж гүйцэтгэдэг.
- Системийн шинжилгээнд үндэслэн программ хангамжийг хөгжүүлэх нь хэрэглэгчийн шаардлага, бизнес үйл ажиллагаанаас аливаа шалгуур, алхмыг орхигдуулах эрсдэлийг бууруулж төсөл амжилттай хэрэгжихэд сайнаар нөлөөлдөг.
- Нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлсэн Urban City ERP системийг өөрчлөн тохируулж Urban State ERP бий болгосон



Төслийн үр дүн

- Иргэд, ААН-с бүх төрлийн хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх, шийдвэрлэж буй хүсэлтүүд дээрээ орон зайн мэдээллийг нь оруулах боломжтой болсон.
- Мэдээллийн санд хүссэн тооны давхаргын төрлүүдийг үүсгэх, тэдгээр давхаргууд дээрээ бүртгэх атрибут үзүүлэлтийг хүсэлтийн төрөл бүрээр динамикаар тохируулах боломжтой.
- Стандартын дагуу орон зайн давхаргын өнгө, хэв маягийг админ өөрчлөн удирдах боломжтой.
- Байгууллагын бүтцийг бүртгэх, хэрэглэгчийн эрхийг тохируулах боломжтой.
- Мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг шалгах шалгууртай болсон.
- Хүсэлтийн төрөл бүрээр байгууллагын дотоод үйл ажиллагааны процессын дагуу ажлын урсгал үүсгэж тохируулах боломжтойгоор хийгдсэн тул ирээдүйн программ хангамж хөгжүүлэлтийн зардлыг бууруулсан.
- Хүсэлт, бүртгэлүүдтэй холбоотой хавсралт файл, батлагдсан файлууд цахим архивын нэгдсэн санд хадгалагддаг болсон.

Төслийн мэдээлэл

Захиалагч: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар

Санхүүжүүлэгч: Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам

Хэрэгжүүлсэн огноо: 2023он

Нээлттэй портал: www.urban.gov.mn

Гар утасны апп: Urban: Cadastral System

4

Улсын газрын биржийн систем (Land Auction System)

Төслийн тухай товч

Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны санхүүжилттэйгээр газрын биржийн системийн техник технологи болон дотоод үйл ажиллагааны сайжруулалтыг хийж хэрэгжүүлэхээр эхэлсэн. Үүний хүрээнд газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт, газрын зах зээлийн үнийн мэдээлэл цуглуулах, газрын нөөц сан болон худалдаа, түрээсийн мэдээлэл оруулах зэрэг ажлуудыг дахин загварчлан хөгжүүлсэн.

Шийдвэрлэх асуудал

Техник, технологийн хувьд:

- Одоо байгаа техник дэд бүтцийг өргөжүүлэн сайжруулж өргөтгөн дахин загварчлах
- Дуудлага худалдааны явцыг таслалтгүй явуулах боломжийг бүрдүүлэх
- Одоо ашиглагдаж буй фраймворк болон серверүүдийн хувилбаруудыг хамгийн сүүлийн байдлаар шинэчлэх
- Хэрэглэгчийн талд нэгдсэн цагийн хяналт бий болгох

Үйл ажиллагааны хувьд:

- Сүүлийн үеийн загвар дизайн бүхий портал сайт болон дотоод удирдлагын системийг хөгжүүлэх
- Дуудлага худалдаа болон төсөл сонгон шалгаруулалтад оролцож буй газрын мэдээллийг газрын нэгдсэн системээс дэлгэрэнгүй байдлаар дуудаж холбох
- Газрын нөөц сан бүрдүүлэхдээ газрын кадастр, газар зохион байгуулалт болон өөрсдөө зурж оруулах (Shapefile) боломжийг бүрдүүлэх
- Дуудлага худалдаа болон төсөл сонгон шалгаруулалтад шалгарсан иргэн болон ААНтэй гэрээ болон газрын өргөдөл зэргийг автоматаар үүсгэх боломжийг бүрдүүлэх
- Дуудлага худалдааны тэмдэглэлийг системээс автоматаар үүсгэх г.м асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай болсон.

Нэвтрүүлсэн шийдэл

Техник, технологийн хувьд:

- Газрын биржийн системийн үндсэн платформыг Laravel фреймворк дээр хөгжүүлж, олон нийтэд нээлттэй порталыг React JS фреймворк ашиглан, мэдээллийн сангийн системийг PostgreSQL / PostGIS дээр суурилсан.
- Дуудлага худалдаан оролцох үе буюу портал болон үндсэн платформ хооронд Socket - оор мэдээллийг дамжуулж үнийн санал өгөх боломжтой болсон.
- Дотоод удирдлагын систем, нээлттэй портал болон мэдээллийн сангийн системүүдийг өөр өөр сервер дээр тохируулах боломжтойгоор хөгжүүлсэн.

Үйл ажиллагааны хувьд:

- Нээлттэй порталын хувьд шинэ дизайн, өнгө төрхтэйгөөр хөгжүүлэлтийг хийсэн
- Иргэн ААН нэгжийн таних төрийн танилт нэвтрэлтийн ДАН системийг холбосон.
- Дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтыг газрын удирдлагын нэгдсэн системтэй холбосон.
- Үнийн мэдээлэл болон бусад тайлан мэдээг хурдан шуурхай гаргах байдлаар мэдээллийн сангийн зохион байгуулалтын хийсэн

Дуудлага худалдаа

Бүртгэл 2 Газрын мэдээлэл 3 Дуудлага худалдааны мэдээлэл 4 Нэмэлт мэдээлэл

5 Хяаралт материалууд 6 360° зураг

Тухайн сонгосон Сүм/Дүүргийн кадастраас хайх? Хайх

Кадастрын мэдээллийн сангаас хайх

8516008621 Хайх

Нэгж төлбөрийн дугаар 8516008621 Хөдөөн / Байр Худалдааны

Газрын хэмжээ, м² 5400 Хамта / Тогт

Газрын төрөл 2110 Худалдаа, нийтийн ү... Хөдөөн дэлгэрэнгүй

Эхний төлбөр Эхний өдөр 2014-06-06

Зөвлөхөөний огцроо

☒ Газрын дэлгэрэнгүй бүртгэл

Хэдэн тал хэвч болж

Хэрэглээний байдал Сонгох Усжууралтын технологийн үнэ

Илчлөлийн хяналтын байгуулалт

Нэмэлт мэдээлэл

☒ Цахилгаантай эсэх ☐ Телефон утасны шугамд холбогдсон эсэх

☐ Үерийн далайд ойр эсэх ☐ Бөхийн эх үүсвэрийн шугамд холбогдсон эсэх

Төслийн үр дүн

Газрын дуудлага худалдаа болон төсөл сонгон шалгаруулалт нь Улсын төсвийг тодорхой хэмжээгээр бүрдүүлдэг учир үйл ажиллагаа болон найдвартай байдлыг тогтмол хангаж байх учиртай. Мөн байнгын сайжруулалт хийж сүүлийн үеийн техник, технологийг ашиглах, бусад системүүдтэй холбогдож иргэд олон нийтэд дэлгэрэнгүй мэдээллийг хүргэх шаардлагын хүрээнд хөгжүүлэгдсэн. Одоогийн байдлаар газрын удирдлагын систем болон улсын хот байгуулалтын системтэй холболт хийж шаардлагатай мэдээллүүдийг олон нийтэд харуулж байна.

ББ Дуусах хугацаа (ДХ өмгөжмөх буй) - (Цахим) 00:00:52 #2025-00576 - ЗАВХАН, ТҮДЭВТЭЙ, 3-Р БАГ, ЦОРГО <table><thead><tr><th>Харгалгч</th><th>Огноо</th><th>Үнэ</th></tr></thead><tbody><tr><td>#14940</td><td>15-09-02.399</td><td>1,699,200₮</td></tr><tr><td>#14952</td><td>15-08-57.299</td><td>1,649,200₮</td></tr><tr><td>#14940</td><td>15-08-11.298</td><td>1,599,200₮</td></tr><tr><td>#14952</td><td>15-08-06.209</td><td>1,549,200₮</td></tr><tr><td>#14940</td><td>15-07-14.258</td><td>1,499,200₮</td></tr></tbody></table> А. 3 Орлогчид байна	Харгалгч	Огноо	Үнэ	#14940	15-09-02.399	1,699,200₮	#14952	15-08-57.299	1,649,200₮	#14940	15-08-11.298	1,599,200₮	#14952	15-08-06.209	1,549,200₮	#14940	15-07-14.258	1,499,200₮	ББ Дуусах хугацаа (ДХ өмгөжмөх буй) - (Цахим) 00:00:52 #2025-00579 - ЗАВХАН, ТҮДЭВТЭЙ, 5-Р БАГ, ШАР НҮГ <table><thead><tr><th>Харгалгч</th><th>Огноо</th><th>Үнэ</th></tr></thead><tbody><tr><td>#14987</td><td>15-09-02.910</td><td>150,238,400₮</td></tr><tr><td>#14940</td><td>15-08-55.233</td><td>145,238,400₮</td></tr><tr><td>#14987</td><td>15-08-47.782</td><td>144,238,400₮</td></tr><tr><td>#14940</td><td>15-08-34.764</td><td>139,238,400₮</td></tr><tr><td>#14987</td><td>15-08-29.572</td><td>138,238,400₮</td></tr></tbody></table> А. 3 Орлогчид байна	Харгалгч	Огноо	Үнэ	#14987	15-09-02.910	150,238,400₮	#14940	15-08-55.233	145,238,400₮	#14987	15-08-47.782	144,238,400₮	#14940	15-08-34.764	139,238,400₮	#14987	15-08-29.572	138,238,400₮	ББ Дуусах хугацаа (ДХ өмгөжмөх буй) - (Цахим) 00:00:56 #2025-00574 - ЗАВХАН, ТҮДЭВТЭЙ, 3-Р БАГ, ЦОРГО <table><thead><tr><th>Харгалгч</th><th>Огноо</th><th>Үнэ</th></tr></thead><tbody><tr><td>#14958</td><td>15-09-06.704</td><td>1,568,400₮</td></tr><tr><td>#14940</td><td>15-09-04.322</td><td>1,518,400₮</td></tr><tr><td>#14958</td><td>15-08-48.192</td><td>1,468,400₮</td></tr><tr><td>#14958</td><td>15-08-48.192</td><td>1,468,400₮</td></tr><tr><td>#14940</td><td>15-08-24.327</td><td>1,418,400₮</td></tr></tbody></table> А. 3 Орлогчид байна	Харгалгч	Огноо	Үнэ	#14958	15-09-06.704	1,568,400₮	#14940	15-09-04.322	1,518,400₮	#14958	15-08-48.192	1,468,400₮	#14958	15-08-48.192	1,468,400₮	#14940	15-08-24.327	1,418,400₮
Харгалгч	Огноо	Үнэ																																																						
#14940	15-09-02.399	1,699,200₮																																																						
#14952	15-08-57.299	1,649,200₮																																																						
#14940	15-08-11.298	1,599,200₮																																																						
#14952	15-08-06.209	1,549,200₮																																																						
#14940	15-07-14.258	1,499,200₮																																																						
Харгалгч	Огноо	Үнэ																																																						
#14987	15-09-02.910	150,238,400₮																																																						
#14940	15-08-55.233	145,238,400₮																																																						
#14987	15-08-47.782	144,238,400₮																																																						
#14940	15-08-34.764	139,238,400₮																																																						
#14987	15-08-29.572	138,238,400₮																																																						
Харгалгч	Огноо	Үнэ																																																						
#14958	15-09-06.704	1,568,400₮																																																						
#14940	15-09-04.322	1,518,400₮																																																						
#14958	15-08-48.192	1,468,400₮																																																						
#14958	15-08-48.192	1,468,400₮																																																						
#14940	15-08-24.327	1,418,400₮																																																						
ББ Дуусах хугацаа (ДХ өмгөжмөх буй) - (Цахим) 00:00:58 #2025-00578 - ЗАВХАН, ТҮДЭВТЭЙ, 3-Р БАГ, ЦОРГО <table><thead><tr><th>Харгалгч</th><th>Огноо</th><th>Үнэ</th></tr></thead><tbody><tr><td>#11688</td><td>15-09-09.983</td><td>11,436,960₮</td></tr><tr><td>#14940</td><td>15-09-08.305</td><td>11,336,960₮</td></tr><tr><td>#11688</td><td>15-09-01.377</td><td>11,236,960₮</td></tr><tr><td>#11688</td><td>15-09-01.377</td><td>11,236,960₮</td></tr></tbody></table> А. 3 Орлогчид байна	Харгалгч	Огноо	Үнэ	#11688	15-09-09.983	11,436,960₮	#14940	15-09-08.305	11,336,960₮	#11688	15-09-01.377	11,236,960₮	#11688	15-09-01.377	11,236,960₮	ББ Дуусах хугацаа (ДХ өмгөжмөх буй) - (Цахим) 00:00:00 #2025-00577 - ДУНДГОВЬ, ЭРДЭНЭДАЛАЙ, 7-Р БАГ, 1 <table><thead><tr><th>Харгалгч</th><th>Огноо</th><th>Үнэ</th></tr></thead><tbody><tr><td>#14940</td><td>15-07-54.304</td><td>1,216,800₮</td></tr><tr><td>#14989</td><td>15-07-47.867</td><td>1,166,800₮</td></tr><tr><td>#14940</td><td>15-06-49.587</td><td>1,116,800₮</td></tr><tr><td>#14989</td><td>15-06-32.213</td><td>1,066,800₮</td></tr></tbody></table> А. 3 Орлогчид байна	Харгалгч	Огноо	Үнэ	#14940	15-07-54.304	1,216,800₮	#14989	15-07-47.867	1,166,800₮	#14940	15-06-49.587	1,116,800₮	#14989	15-06-32.213	1,066,800₮	ББ Дуусах хугацаа (ДХ өмгөжмөх буй) - (Цахим) 00:00:00 #2025-00575 - ЗАВХАН, ТҮДЭВТЭЙ, 3-Р БАГ, ЦОРГО <table><thead><tr><th>Харгалгч</th><th>Огноо</th><th>Үнэ</th></tr></thead><tbody><tr><td>#14940</td><td>14-58-43.411</td><td>255,200₮</td></tr><tr><td>#14953</td><td>14-41-47.138</td><td>205,200₮</td></tr><tr><td>#14940</td><td>12-50-53.397</td><td>155,200₮</td></tr><tr><td>#14953</td><td>10-32-25.663</td><td>105,200₮</td></tr></tbody></table> А. 3 Орлогчид байна	Харгалгч	Огноо	Үнэ	#14940	14-58-43.411	255,200₮	#14953	14-41-47.138	205,200₮	#14940	12-50-53.397	155,200₮	#14953	10-32-25.663	105,200₮									
Харгалгч	Огноо	Үнэ																																																						
#11688	15-09-09.983	11,436,960₮																																																						
#14940	15-09-08.305	11,336,960₮																																																						
#11688	15-09-01.377	11,236,960₮																																																						
#11688	15-09-01.377	11,236,960₮																																																						
Харгалгч	Огноо	Үнэ																																																						
#14940	15-07-54.304	1,216,800₮																																																						
#14989	15-07-47.867	1,166,800₮																																																						
#14940	15-06-49.587	1,116,800₮																																																						
#14989	15-06-32.213	1,066,800₮																																																						
Харгалгч	Огноо	Үнэ																																																						
#14940	14-58-43.411	255,200₮																																																						
#14953	14-41-47.138	205,200₮																																																						
#14940	12-50-53.397	155,200₮																																																						
#14953	10-32-25.663	105,200₮																																																						

Төслийн мэдээлэл

Захиалагч: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар

Санхүүжүүлэгч: Нийслэлийн газар зохион байгуулалтын алба

Хэрэгжүүлсэн огноо: 2024он

Нээлттэй портал: www.mle.mn

5

Газрын үйлчилгээний киоск машин (Land Kiosk)

Төслийн тухай товч

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас иргэд олон нийтэд үзүүлдэг үйлчилгээнүүдийг киоск машинаар дамжуулан хурдан шуурхай, хүртээмжтэй байхаар зохион байгуулан хөдөө орон нутаг болон дүүргүүд дээр байршуулсан. Газрын харилцааны үйлчилгээний Киоск машин нь иргэд, аж ахуй нэгж, байгууллагуудад газрын харилцаатай холбоотой нийт 70 орчим төрлийн үйлчилгээ үзүүлэх боломжтой ба 52 төрлийн өргөдөл, хүсэлтийг цахимаар гаргах, шийдвэрлүүлэх, 12 төрлийн мэдээлэл, лавлагаа, тодорхойлолтыг үнэ төлбөргүй хэвлэн авах, мөн цахим хүсэлт, өргөдлийнхөө шийдвэрлэлтийн явцыг шалгах, цахим гэрээ, гэрчилгээ үүсгэх, газрын төлбөр шалгах, газрын төлбөрөө QR-аар төлөх зэрэг үйлчилгээнүүдтэй болно

Шийдвэрлэх асуудал

Газрын үйлчилгээнүүдийг киоск машинаар үзүүлэх үйлчилгээнүүд нь анх удаа хийгдэж байгаа бөгөөд иргэнийг газрын системд бүртгэлтэй гар утасны дугаар болон иргэний үнэмлэхээр таних үйл ажиллагаанаас эхлэн шийдвэрлэх асуудлууд бий болсон. Мөн бүх үүрэн холбооны дугаарлуу мессеж явуулах, кадастрын зургыг тухай бүрт нь шинээр зураглах зэрэг шийдлүүдийг хэрэгжүүлэх шаардлага үүссэн.



Нэвтрүүлсэн шийдэл

Техник, технологийн хувьд:

- Монгол Улсын хаанаас ч киоскны машинаар дамжуулан газрын үйлчилгээг авах боломжтой болсон.
- Газрын үйлчилгээний киоск машин дээр иргэн, ААН - н бүртгэлтэй утасны дугаарлуу мессеж явуулах танин нэвтрүүлдэг болсон.
- Иргэний үнэмлэхийг уншин, иргэний регистрийн дугаараар танин нэвтрүүлдэг болсон.
- Газрын албан дээр байрлах газартай холбоотой бүх төрлийн цахим файлуудыг татаж хэвлэн авдаг болсон.

Үйл ажиллагааны хувьд:

- Иргэн, ААН - н газрын кадастрын зургыг тухай бүрт нь үүсгэж, хамгийн сүүлийн байдлаар хэвлэх боломж бүрдсэн.
- Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал өгөх боломж бүрдсэн.
- Өөрийн газартай холбоотой хүсэлтүүдийг илгээдэг болсон.
- Зарим төлбөртэй үйлчилгээг QRay ашиглан төлдөг болсон.



Төслийн үр дүн

Газрын үйлчилгээний киоск машиныг Улс орон даяар хэрэгжүүлсэнээр иргэн, ААН дан ганц газрын албанаас очиж үйлчилгээ авхаас илүүтэй дурын киоск байгаа газар дээр очин үйлчилгээг түргэн шуурхай авах боломж бүрдсэн. Хамгийн их өргөн хэрэглэгддэг үйлчилгээ болох газрын кадастрын зураг, гэрчилгээ болон гэрээ байсаар байна. Мөн энэхүү үйлчилгээг төлбөртэй болгосноор киоск машин ажиллуулахтай холбоотой урсгал зардлуудыг хаадаг болсон.

Өмнө нь иргэд газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрээ, гэрчилгээ, кадастрын зураг, газрын төлөв байдал чанарын хянан баталгааны дүгнэлт, газрын барьцаа, төлбөрийн мэдээлэл зэрэг төрийн үйлчилгээг авахад 6-10 гарын үсэг зурагдаж дээрх бичиг баримт олгогддог байсан бол цахим машиныг нэвтрүүлснээр иргэн, хуулийн этгээд нийт 18 төрлийн үйлчилгээг нэг дороос 1 минутын дотор авах боломжтой болсон

Төслийн мэдээлэл

Захиалагч: Газар Зохион Байгуулалт, Геодези, Зураг Зүйн Ерөнхий Газар
Хэрэгжүүлсэн огноо: 2023он - 2025он

6

Нийслэлийн зам, замын байгууламжийн бүртгэлийн систем (Road ERP)

Төслийн тухай товч

Нийслэлийн авто зам, замын байгууламжийн мэдээллийг хэрэглэгчийн шаардлагад нийцүүлэн мэдээлэх орон зайн мэдээлэлд суурилсан удирдлагын нэгдсэн систем нэвтрүүлэх, мэдээллийн сангийн суурь өгөгдлийг баяжуулан нэгдсэн мэдээллийн санг баяжуулах, мэдээллийн чанар, нарийвчлалыг сайжруулахад оршино.

Шийдвэрлэх асуудал

Техник, технологийн хувьд:

- Вэб технологи дээр суурилсан удирдлагын нэгдсэн систем бий болгох шаардлага
- Олон нийтэд нээлттэй портал сайт болон гар утасны апп бий болгох шаардлага
- Шинээр сервер, тоног төхөөрөмж худалдан авах, түүн дээрээ системүүдээ тохируулан ажиллуулах шаардлага
- Одоо байгаа ArcGIS системээс өгөгдөл мэдээллийг хөрвүүлэн оруулах шаардлага г.м.

Үйл ажиллагааны хувьд:

- Сүүлийн үеийн загвар дизайн бүхий портал сайт болон дотоод удирдлагын системийг хөгжүүлэх
- Замын хөгжлийн газар дээр явагдаж буй захирамж, гэрээ, зөвшөөрөл г.м бүх үйл ажиллагааны бизнес процесс загварчлалыг бий болгох
- Иргэн, ААН нэгжээс Замын хөгжлийн газартай холбоотой хүсэлт, өргөдөл гомдол шийдвэрлэх үйл ажиллагааг цахимаар өгдөг болгох
- Замын удирдлагын нэгдсэн системийг газрын удирдлагын нэгдсэн системтэй холбох
- Замын удирдлагын нэгдсэн системийг Хот байгуулалт, хотын стандартын газрын Хот байгуулалтын системтэй холбох
- Нийт албан хаагч, мэргэжилтэнгүүдэд сургалт явуулах, нэвтрүүлэх г.м.


Нэвтрүүлсэн шийдэл

Техник, технологийн хувьд:

- Өмнө хэрэгжүүлж байсан системүүдийн адил өөрсдийн Орон зайн удирдлагын нэгдсэн платформыг тохируулан суурилуулсан
- Гар утасны апп (React Native) болон вэб системүүдийг (Laravel Framework) дээр суурилан хөгжүүлсэн
- Газрын зургын систем нь (Geo Server) дээр суурилан хөгжүүлэгдсэн

Үйл ажиллагааны хувьд:

- Нээлттэй порталын хувьд шинэ дизайн, өнгө төрхтэйгөөр хөгжүүлэлтийг хийсэн.
- Иргэн, ААН нэгжийн таних төрийн танилт нэвтрэлтийн ДАН системийг холбосон.
- Бүх төрлийн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх боломжтой болсон. (Тэмдэг тэмдэглэгээ, талбайн шинжилгээ, зөвшөөрөл г.м 40 гаруй хүсэлтийг шийдвэрлэдэг болсон.)
- Олон төрлийн бүртгэлийг хийх боломжтой болсон. (Захирамж, гэрээ, төсөл арга хэмжээ, захиалагчийн хяналт г.м - ээр нэмэх нэмдэг болсон.)
- Бүх төрлийн орон зайн давхаргыг бүртгэх боломжтой болсон.



Төслийн үр дүн

Нийслэлийн хэмжээний нийт зам, замын байгууламжын нэгдсэн мэдээллийн сан үүсгэсэн. Мөн дотоод үйл ажиллагааны бизнес процессыг зураглан гаргаж, шаардлагатай үйл ажиллагаануудыг програмчлан бий болгосон. Иргэд, ААН-ээс олон төрлийн хүсэлтийг авч шийдвэрлэн нээлттэй порталаар дамжуулан хүргэдэг болсон.

Төслийн мэдээлэл

Захиалагч: Замын Хөгжлийн Газар

Санхүүжүүлэгч: Замын Хөгжлийн Газар

Хэрэгжүүлсэн огноо: 2024он

Нээлттэй портал: www.ubroad.mn

7

Цахилгаан байгууламжийн бүртгэл мэдээллийн систем (Grid platform)

Төслийн тухай товч

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээний улсын хэмжээний дэд станц, агаарын шугам, тулгууруудыг орон зайн байршлаар нь бүртгэн оруулах, тухайн байгууламжын дэлгэрэнгүй мэдээлэл, өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах бүртгэл мэдээллийн систем. Дэд станц болон тулгууруудын тоноглол бүрийг бүртгэн, тоноглол дээрх үйл ажиллагаануудыг удирдан зохион байгуулдаг.

Шийдвэрлэх асуудал

Техник, технологийн хувьд:

- Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээний салбар байгууллагууд интернетийн орчинд вэбээр хандан үйл ажиллагаагаа явуулах боломж
- Цахилгаан байгууламж бүрийг орон зайн байршлаар нь бүртгэн оруулах боломж
- Дэд станцын тоноглол ба түүний схемийг вэб систем дээр зураглах, дээр ажиллах боломж
- Орон зайн мэдээллийг 2D болон 3D байдлаар газар зүйн систем дээр харах

Үйл ажиллагааны хувьд:

- Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээний бүх албан хаагчдыг хандах нэгдсэн удирдлагын систем бий болгох
- Өдөр тутмын бүхий л ажиллагааг систем дээр удирдан авч явах. Үүнд: Таслалт, Тасралт, Гэмтэл, Захиалга, Хязгаарлалт, Ачаалал, Энергийн баланс, Шуурхай г.м үйл ажиллагаануудыг бүртгэн удирдах
- Мэргэжилтэнгүүд тоноглолын схем дээр шууд ажиллан бүртгэл мэдээллийг хөтлөх зэрэг асуудлуудыг шийдвэрлэх шаардлага гарсан.



Нэвтрүүлсэн шийдэл

Техник, технологийн хувьд:

- Өмнө хэрэгжүүлж байсан системүүдийн адил өөрсдийн Орон зайн удирдлагын нэгдсэн платформыг тохируулан суурилуулсан
- Вэб системүүдийг (Laravel Framework) болон бусад шаардлагатай технологиудыг ашиглан хөгжүүлсэн
- Газрын зургын систем нь (Geo Server) дээр хөгжүүлэгддэг бөгөөд OpenLayers болон CesiumJS технологи ашиглан харуулдаг



Үйл ажиллагааны хувьд:

- Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээний бүхий л цахилгаан байгууламжуудыг орон зайн байршлаар бүртгэх оруулсан
- Өдөр тутмын үйл ажиллагаануудыг цахилгаан байгууламж, тоноглол дээр суурилан бүртгэн удирддаг болсон
- Дэд станцуудын тоноглолуудыг схем дээр суурилан зураглан харж ажилладаг болсон. (AutoCAD болон QGIS дээр зураглан оруулах боломжтой болсон)
- Цахилгаан байгууламжуудыг 2D болон 3D газар зүйн систем дээр харах, мөн бусад хамтран ажиллагч байгууллагуудтай давхцуулан хардаг болсон. (Жишээ нь: Цахилгаан түгээх сүлжээ)



Төслийн үр дүн

Улсын хэмжээний нийт дэд станц, тулгуур, агаарын шугамыг орон зайн байршил болон холбогдох мэдээллүүдийн хамт бүртгэж оруулсан. Мөн тухайн цахилаан байгууламжуудын тоноглолуудыг схемийн дагуу зураглан оруулсан. Өдөр тутмын үйл ажиллагааг тоноглол дээр суурилан явуулдаг болсон.



Төслийн мэдээлэл

Захиалагч: Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ ТӨХК

Санхүүжүүлэгч: Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ ТӨХК

Хэрэгжүүлсэн огноо: 2025он

Нээлттэй портал: www.grid.transco.mn

Бидэнтэй холбоо барих

Та хамтран ажиллах, санал хүсэлт зэргээр
бидэнтэй холбогдоорой.



Хаяг

502, World Wine Center,
Баянгол дүүрэг, 26 хороо, Улаанбаатар хот



Утас

+(976)7272-7002



И-Мэйл

contact@smartdata.mn



Вэб сайт

www.smartdata.mn